



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 490

Улаанбаатар хот

### Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлгийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,716,140,000.00 (нэг тэрбум долоон зуун арван зургаан сая нэг зуун дөчин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг Боловсрол, шинжлэх ухааны яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт тус тус балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Газар эзэмших эрхийг шилжүүлэн баталгаажуулж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003486

26-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны дугаар сарын 28-ны өдрийн  
20 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА 401 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ  
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ,  
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Богдхан уулын ДЦГ, Зайсангийн ам)	2018	га	1.6	518,080,000.00	Боловсрол, шинжлэх ухааны яам
			га	3.7	1,198,060,000.00	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
	Нийт дүн				1,716,140,000.00 (нэг тэрбум долоон зуун арван зургаан сая нэг зуун дөчин мянган)	